



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/194.

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дэх хэсэг, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Тус аймгийн Норовлин сумын “Ар бэрх”, Цэнхэрмандал сумын “Уртын ам” гэдэг газарт гарсан ой хээрийн түймрийг унтраахад гарсан зардалд 22807360 /хорин хоёр сая найман зуун долоон мянга гурван зуун жаран/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшигтай тэмцэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуунд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 968

Аймгийн Засаг даргын 2017 оны  
05 дугаар сарын 22 өдрийн 1/194  
дугаар захирамжийн хавсралт

### ЗАРДЛЫН ТООЦОО

№	Сумын нэр	Газрын нэр	Он, сар, өдөр	Зардлын нэр			Дүн
				Хоолны зардал	Шатахууны зардал	Сэлбэг хэрэгсэл	
1	Норовлин сум	Онон багийн нутаг "Ар Бэрх"	2017.04.28	1,300,000	4,000,000		5,300,000
2	Дадал сум			258,000	700,000		958,000
3	Цэнхэрмандал сум	Согоот багийн нутаг "Уртын ам"	2017.04.30	1,200,000	3,226,250		4,426,250
4	Өмнөдэлгэр сум			400,000	2,257,820		2,657,820
5	Жаргалтхаан сум			290,690	927,500		1,218,190
6	Онцгой байдлын газар	"Ар Бэрх", "Уртын ам"	2017.04.28 -30		1,397,100	6,500,000	7,897,100
7	Аймгийн ЗДТГ			350,000			350,000
	<b>Бүгд</b>			<b>3,798,690</b>	<b>12,508,670</b>	<b>6,500,000</b>	<b>22,807,360</b>